



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/Н/5

Баян-Овоо

**Эрсдэлийн сангаас зардал гаргах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.9 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Агац багийн нутаг Өвөр Улаалзаргана гэх газарт 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр гарсан ой хээрийн түймрийн хоол хүнсний зардал 222600 (Хоёр зуун хорин хоёр мянга зургаан зуун) төгрөг, шатахууны зардал 646580 (Зургаан зуун дөчин зургаан мянга таван зуун наян) төгрөгийн зардлыг тус тус гаргасугай.

2.Дээрхи 869180 (Найман зуун жаран есөн мянга нэг зуун наян) төгрөгийн зардлыг эрсдлийн сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД